

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны дүгээр
сарын ... ны өдөр

Улаанбаатар хот

АГААРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Агаарын тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл нэмсүгэй:

1/ 29¹ дүгээр зүйл:

“29¹ дүгээр зүйл. Агаарын бохирдлын эсрэг сан

29¹.1. Агаарын бохирдлын эсрэг сангийн /цаашид “сан” гэх/ үйл ажиллагааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулна.

29¹.2. Сангийн төсвийн ерөнхийлөн захирагч нь байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

29¹.3. Сан нь түүний үйл ажиллагааг зохицуулах орон тооны бус Удирдах зөвлөлтэй байх бөгөөд дарга нь энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11¹–д заасан Үндэсний хорооны дарга байна.

29¹.4. Энэ хуулийн 29¹.3-т заасан Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайд батална.”

29¹.5. Энэ хуулийн 29¹.3-т заасан Удирдах зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газар батална.

2 дугаар зүйл. Агаарын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “мэргэжлийн алба” гэсний дараа “, бүх шатны Засаг дарга” гэж, 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “эх үүсвэрийн” гэсний дараа “мэдээлэл болон” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Агаарын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг:

“31.2. Энэ хуулийн 8 дугаар 8.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, 12.5 дахь хэсэгт заасан журам, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт заасан журмыг зөрчсөн, хүлээсэн үүргээ биелүүлээгүй албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

4 дүгээр зүйл. Агаарын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “энэ хуульд заасан” гэснийг “энэ хуулийн 9.1.8 дахь заалт, 16.1, 20.6, 21.5 дахь хэсэгт заасан” гэж.

5 дугаар зүйл. Энэ хуулийг ердийн журмын дагуу дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны дүгээр
сарын ... ны өдөр

Улаанбаатар хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, заалт нэмсүгэй.

1/ 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 42 дахь заалт:

“5.4.42. Агаарын бохирдлын эсрэг сан.”

2/ 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 24 дэх заалт:

“6.4.24. Агаарын бохирдлын эсрэг сан.”

3/ 12² дугаар зүйл:

“12² дугаар зүйл. Агаарын бохирдлын эсрэг сан

12².1.Агаарын бохирдлын эсрэг сангийн хөрөнгө нь энэ хуулийн 7.1-д зааснаас гадна дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

12².1.1.агаарын бохирдлын төлбөрийн орлого 100 хувь, нөхөн төлбөр;

12².1.2.бусад орлого.

12².2.Энэ хуулийн 12².1-д заасан сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

12².2.1.агаарыг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

12².2.2.стандартын шаардлагад нийцсэн цэвэр түлш, зуух үйлдвэрлэхийг дэмжих, тэдгээрийг худалдан авахад хөнгөлөлт үзүүлэх;

12².2.3.агаарын чанарын хяналт-шинжилгээний чадавхыг бэхжүүлэх, хэмжилтийн багаж төхөөрөмж худалдан авах, агаарын чанарын төлөв байдлын хувьсал өөрчлөлтийг судлан тогтоох болон агаарыг хамгаалахтай холбогдолтой стандарт, норм, дүрэм, арга, аргачлал боловсруулах, судалгаа, шинжилгээний төсөл, ажлыг гүйцэтгэх;

12².2.4.эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, барилгын дулаан алдагдлыг бууруулах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

12².2.5.агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн иргэд, олон нийтийн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх;

12².2.6.сэргээгдэх эрчим хүч, цэвэр технологийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх;

12².2.7.агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн олон нийтэд мэдлэг олгох сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулах.”

2 дугаар зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “хуулийн” гэсний дараа “6.4.2” гэж, “6.4.10,” гэсний дараа “6.4.24,” гэж, 6 дахь хэсгийн “хуулийн” гэсний дараа “5.4.2,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг ердийн журмын дагуу дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

---000---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны дүгээр
сарын ... ны өдөр

Улаанбаатар хот

**АГААРЫН БОХИРДЛЫН ТӨЛБӨРИЙН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалт, 4.5 дахь хэсгийн “иргэн” гэснийг “өрх” гэж, 5 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “улсын төсөвт” гэснийг “Агаарын бохирдлын эсрэг санд” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг ердийн журмын дагуу дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

АГААРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2017 оны дүгээр
сарын ... ны өдөр

Улаанбаатар хот

Агаарын тухай хуулийг боловсронгуй болгож, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг нэгдсэн удирдлагатайгөөр төлөвлөж, санхүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, агаарын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд үүрэг хариуцлагыг тодорхой болгох нийгэм эдийн засгийн шаардлага байгаа учраас энэ хууль болон холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл боловсрууллаа.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс 2017 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр “Нийслэлийн агаар, орчны бохирдлын тухай” 03 /03 тушаал гаргаж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс агаарын бохирдол гамшгийн хэмжээнд хүрснийг зарласны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нар хамтран 2017 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр “Агаар чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоох тухай” А/04/09 тоот тушаал гаргаж шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Мөн Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотойгоор дагалдаж Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж байгаа болно. Агаарын тухай хуулийн өөрчлөлтөөр агаарын бохирдлын эсрэг санг байгуулахаар тусгасан. Энэ сан нь агаарыг бохирдохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх, бохирдуулах бодисын хаягдлыг багасгах зорилтын хүрээнд Засгийн газраас хэрэгжүүлж байгаа арга хэмжээг санхүүжүүлэх зорилготой тусгай сан юм.

Дэлхийн бакнаас хийсэн судалгаагаар Улаанбаатар хотын оршин суугчдын хувьд нарийн ширхэгт тоосонцорт өртөж буй тооцоолсон хэмжээ жилийн дунджаар Монгол Улсын агаарын чанарын үндэсний стандартаас даруй 10 дахин, харин Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зорилтот шаардлагаас 6-7 дахин их байна гэсэн үр дүн гарсан байна.

Иймд агаарын бохирдлын эсрэг санг шинээр байгуулснаар агаарыг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, тэдгээрийг худалдан авахад хөнгөлөлт үзүүлэх, агаарын чанарын хяналт-шинжилгээний чадавхийг бэхжүүлэх, агаарын чанарын төлөв байдлын хувьсал өөрчлөлтийг тогтоох болон агаарыг хамгаалахтай холбогдолтой стандарт, норм, дүрэм, арга, аргачлал боловсруулах, судалгаа, шинжилгээний төсөл, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, барилгын дулаалгыг сайжруулах төсөл, агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн иргэд, олон нийтийн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх зэрэг агаарын бохирдлыг бууруулах бусад арга хэмжээг санхүүжүүлэх юм.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

---000---

БАТЛАВ.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

САНГИЙН САЙД

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Д.ОЮУНХОРОЛ

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

С.БЯМБАЦОГТ

АГААРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Агаарын тухай хуулийг боловсронгуй болгож, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг нэгдсэн удирдлагатайгөөр төлөвлөж, санхүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, агаарын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд үүрэг хариуцлагыг тодорхой болгох нийгэм эдийн засгийн шаардлага байгаа учраас энэ хууль, болон холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл боловсрууллаа.

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй...гэж заасан, Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, Мөн Улсын Их хурлаас 2014 онд 43 дугаар тогтоолоор баталсан “Ногоон хөгжлийн бодлого”, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн “Нийслэлийн агаар, орчны бохирдлын тухай” 0303 тоот зөвлөмж, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц (НҮБҮАӨСК)-д 1993 онд нэгдэн орсон бөгөөд Нэгдсэн Үндэсний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн 2015 оны Парисын хэлэлцээр, Засгийн газрын 2016 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хууль тогтоомжийг 2016-2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” зэрэг хууль эрх зүйн томоохон баримт бичгүүдээр эрх зүйн үндэс нь тодорхойлогдсон.

2.1. Практик үндэслэл

Дэлхийн нийтийг хамарсан уур амьсгалын өөрчлөлт, манай улсын томоохон хот суурин газрын агаар, орчны хэт бохирдол нь хүний эрүүл мэндэд хэт сөргөөр нөлөөлөх хэмжээнд хүрч, гамшгийн хэмжээнд хүрээд байна. Улаанбаатар хотын агаар орчны бохирдол нь гэр хороолол, авто машин, цахилгаан станц болон бусад эх үүсвэрээс үүсч байгаа учраас Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж агаарын бохирдлын эсрэг санг шинээр байгуулж агаарыг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, тэдгээрийг худалдан авахад хөнгөлөлт үзүүлэх, агаарын чанарын хяналт-шинжилгээний чадавхийг бэхжүүлэх, агаарын чанарын төлөв байдлын хувьсал өөрчлөлтийг тогтоох болон агаарыг хамгаалахтай холбогдолтой стандарт, норм, дүрэм, арга, аргачлал боловсруулах, судалгаа, шинжилгээний төсөл, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, барилгын дулаалгыг сайжруулах төсөл, агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн иргэд, олон нийтийн үйл ажиллагаа, төсөл, арга

хэмжээнд дэмжлэг үзүүлэх зэрэг агаарын бохирдлыг бууруулах бусад арга хэмжээг санхүүжүүлэх юм.

Хоёр. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь бүтцийн хувьд 5 зүйлээс бүрдэж байгаа бөгөөд 1 дүгээр зүйлээр Агаарын бохирдлын эсрэг сан болон түүний үйл ажиллагааг зохицуулах удирдах , ажиллах журам зэргийг тодорхойлсон, 2 дугаар зүйлээр бүх шатны Засаг дарга нарын үүрэг, оролцоог нэмэгдүүлсэн, 3, 4 дүгээр зүйлээр Агаарын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг илүү нарийвчлан зохицуулсан, 5 дугаар зүйлээр хуулийн дагаж мөрдөх хугацааг зааж өгсөн болно.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараах нийгэм, эдийн засгийн үр дагавар.

Агаарын бохирдлын эсрэг санг байгуулснаар агаарын бохирдлыг бууруулах, сааруулах, шинэ техник, технологи нэвтрүүлэх зэрэг санхүүгийн шинэ үүсвэр татах, хот, суурин газар тулгараад буй агаарын бохирдлыг бууруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулахад чухал үүрэг гүйцэтгэх юм.

Дөрөв. Хуулийн төсөл батлагдсаны дараа уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон цаашид боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаар.

Хуулийн төсөл батлагдсанаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулан сангийн орлогын бүрдүүлэлт, санхүүжүүлэх арга хэмжээ, ажлын алба, хөрөнгийг захиран зарцуулах журмыг тодорхой болгоно. Мөн Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар улсын төсөвт агаар бохирдуулсны төлбөрөөс ихээхэн хэмжээний орлого төвлөрнө. Тухайлбал: 2016 оны жилийн эцсийн байдлаар Татварын ерөнхий газраас ирүүлсэн судалгаагаар агаарын бохирдлын төлбөрөөс жилдээ дундажаар 30 орчим тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрсөн.

---000---